160

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 11 өдөр Дугаар 390 Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 17-ны хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Эх, нярайн эрүүл мэнд" стратегийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох зорилгоор стратегийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, "Үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг шинэчилсэн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхийг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 456 дугаар тушаалаар батлагдсан "Эх, нярайн эрүүл мэнд" стратеги болон тус стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт бүхий хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.УДВАЛ

082396

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 сарын 11 өдрийн 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

"ЭХ, НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| | Стратегийн тодорхойлолт | Шалгуур | Он 2009 | Он 2015 | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| | | ***Нэг. Үр нөлөөний шалгуур*** | | | |
| **Зорилго** | **Эх, нярайн өвчлөл эндэгдлийг бууруулж, Мянганы хөгжлийн дөрөв, тав дахь зорилтод хүрнэ.** | Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлтөд/ | 81.4 | 50 | ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| | | Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 20.2 | 15 | |
| | | Перинатал эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөнд/ | 16.9 | 15 | |
| | | Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/ | 10 | 10 | |
| **Зорилт** | 1. Гэр бүл, хамт олон, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид, зорилтот бүлгийнхний Эсэн мэнд амаржихуйн талаарх мэдлэгийг сайжруулж, нийгэм, улс төр, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн, нийгмийн нөөцийг дайчлах, | 1.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эх, нярайн тусламж, үйлчилгээний зардал | | Өсөлтийн хувь | Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| | | 1.2. Нярайн эндэгдэл улсын дунджаас буурсан аймгуудийн эзлэх хувь | 65.2 | 47.8 | ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| | | 1.3. Эхийн эндэгдэлгүй аймгийн эзлэх хувь | 21.7 | 61 | |
| | 2. Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүрэх саад бэрхшээлийг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, | 2.1. Эх барих эмэгтэйчүүдийн тоо 10 000-д | 2.2 | 2.4 | |
| | | 2.2. Эх баригчийн тоо 10 000-д | 2.5 | 2.8 | |
| | | 2.3. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь | 83.2 | 90.0 | |
| | | 2.4. Жирэмсний хугацаанд 6 түүнээс дээш үзүүлсэн хувь | 84.1 | 90 | |
| | | 2.5. Төрөхөөс гарснаас хойш 72 цагийн дараах эх, нярайн гэрийн эргэлтийн хувь. | 62% | 80% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3. Эх, нярай, эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, нотолгоонд тулгуурласан анагаах ухааны дэвшилтэт шинэ арга технологийг нэвтрүүлэх, | 3.1. Зайн оношилгоог ашиглаж Аймгийн нэгдсэн эмнэлгт тусламж, үйлчилгээ үзүүлсэн эх, нярайн тооны өсөлт | 321 | жилдээ 350-аас дээш | ЭМХТ, ЭХЭМҮТ-ийн тайлан, мэдээ |
| | | 3.2. Перинатал оношилгоонд хамрагдсан эмэгтэйчүүдийн тооны өсөлт | 984 | 2000*аас дээш | ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн тайлан, мэдээ |
| | | 3.3. Үргүйдлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан эмэгтэйчүүд /төрөх насны 1000 эмэгтэйд/ | 0.4 | 1.4 | ЭМЯ, ЭХЭМҮТ-ийн тайлан, мэдээ |
| **Хоер. Үр дүнгийн шалгуур** | | | | | |
| **Үр дүн 1** | **1.1.** Өсвөр үе, оюутан, шилжин суурьшигч, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрэгтэйчүүдэд чиглэсэн тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн НҮЭМ/ Эсэн мэнд амаржихуйн мэдээлэл сурталчилгаа нэмэгдэнэ | 1.1.1. 15-19 насны охидын төрөлтийн түвшин | 40.4 | 35.0* | НҮТС /SISS/,ҮСХ,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| | | 1.1.2.Умайн хүзүүний хавдрын талаар мэдээлэл авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь | 83 | 90* | НҮТС /SISS/,ҮСХ,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| | | 1.1.3.15-49 насны гэрлэсэн хосуудаас жирэмслэхээс сэргийлэх нэг арга мэддэг эрэгтэйн хувь | 98.3 | 99.3* | НҮТС /SISS/,ҮСХ,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| | **1.2.** Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээ нэмэгдэж, хүсээгүй жирэмслэлт буурна | 1.2.1. Гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын хэрэглээ | 53.2 | 55.0 | НҮТС /SISS/,ҮСХ,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| | | 1.2.2. 15-49 насны эмэгтэйчүүдийн дунд ГБТ-ийн хангагдаагүй хэрэгцээ | 22 | 16 | |
| | | 1.2.3.Үр хөндөлтийн түвшин /1000 амьд төрөлтөд/ | 183.3 | 150 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| үр дүн2 | 2 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламжийн хүртээмж, чанар сайжирна. | 2.1. Кесарево хагалгаагаар шийдсэн төрөлтийн эзлэх хувь | 23.7 | 16* | ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| | | 2.2. Төрсний дараах үеийн хүндрэлийн хувь | 1.5 | 1.1 | |
| | | 2.3. Шаардлагатай тохиолдолд үзүүлсэн тусламжтай төрөлт \вакум, хавчуур\-ийн хувь | - | Заалттай тохиолдолд III, II шатлалд 80% I шатанд 50% | |
| | | 2.4. Төрсний дараах 1 цагийн доторх хөхөөр амлуулалт | 81.0 | 90 | |
| | | 2.5. Бага жинтэй нярайн эзлэх хувь | 4.2 | 4.0 | |
| | | 2.6. Төрсний дараа эх, нярайг арьс арьсаар шүргэлцүүлсэн хувь | 33 | 75 | Үнэлгээгээр |
| | | 2.7.Төрөлт бүрт нэг удаагийн цомог хэрэглэх хувь | *60% | 100% | |
| | | 2.8. Сумын эмчийн хангалт стандартын түвшинд хүрсэн | 67.7 | 100 | ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| | | 2.9. Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь | 66.0 | 95 | |
| Үр дүн 3 | **3.1.** ЭНЭШТөвийн эрдэм судлал, сургалт, зөвлөх үйлчилгээний чадавх бэхжинэ. | 3.1.1. Стационарт эндсэн эхийн тоо | 0.12 | 0.06* | ЭХЭМҮТ |
| | | 3.1.2. Стацианарт эндсэн хүүхдийн нас баралтын хувь | 2.9 | 2.1* | |
| | **3.2.** Пренатал оношилгоо эмчилгээний дэвшилтэт арга технологи нэвтэрсэн байна. | 3.2.1. Амьгүй төрөлтийн түвшин | 7.0 | 5.5 | ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| | | 3.2.2. Төрөлхийн гажигтай төрсөн хүүхдийн эзлэх хувь | 3.4 | 3.4* | |
| | | 3.2.3. Нярайн өвчлөл 1000 амьд төрсөн нярайд | 141.7 | 139.0 | |
| | | 3.2.4. Нярайн нас баралт1000 амьд төрсөн нярайд | 12.7 | 9.4 | |
| | | 3.2.5. Үргүйдлийн түвшин /төрөх насны 1000 эмэгтэйд/ | 0.4 | 0.4* | |
| | **3.3.** Хөх болон умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэлтийн тандалтыг нэвтрүүлсэн байна. | 3.3.1. I, II үе шатандаа оношлогдсон умайн хүзүүний хорт хавдрын хувь | 38.4 | 62.0* | |
| | | 3.3.2. I, II үе шатандаа оношлогдсон хөхний хорт хавдрын хувь | 51.3 | 68.0* | |

164

*ТАЙЛБАР:* 3.1. Зайн оношлогоо 2008 онд анх нэвтэрсэн, 2014 онд 21 аймаг холбогдож, үйл ажиллагаагаа явуулж байна. Жилд 300 үйлчлүүлэгчдэд зайн оношлогоогоор тусламж үзүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн.

3.2.ЭХЭМҮТ-ийн удам зүйн кабинет 2014 оны эхний 6 сарын байдлаар 984 үйлчлүүлэгч хамрагдсан.

1.1.1; 1.1.2. 2013 оны хамгийн бага түвшин

1.1.3. 2013 онд хүрсэн түвшингээс буурахгүй байх

2.1. ДЭМБ-ын дундаж үзүүлэлт

2.7.2013 оны үнэлгээ

3.1.1. Сүүлийн 5 жилийн дундаж

3.1.2.Сүүлий 5 жилийн хамгийн доод түвшин

3.2.2.Сүүлийн 5 жилийн хугацаанд жил бүр нэмэгдэж байгаа

3.2.5.Сүүлийн 5 жилийн хугацаанд үргүйдлийн түвшин ихсэх хандлагатай байгаа

3.3.2. 2013 оны эрүүл мэндийн үзүүлэлтэд суурилав.

165

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
11 сарын 11 өдрийн 390 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

# ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД (2011-2015) СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

## ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| | Үйл ажиллагаа | Шалгуур | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|
| **Стратегийн зорилт- 1. Гэр бүл, хамт олон, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид, зорилтот бүлгийнхний Эсэн мэнд амаржихуйн талаарх мэдлэгийг сайжруулж, нийгэм, улс төр, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн нийгмийн нөөцийг дайчлах** | | | |
| **1** | Иргэний бүртгэл мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнууд болон бүх шатны шийдвэр гаргагч нарыг НҮЭМ/ Эсэн мэнд амаржихуйн чиглэлээр сургалтад хамруулан, ухуулга сурталчилгаа хийх | Аймаг, дүүрэг, сум хорооны шийдвэр гаргагч нарын 80-аас доошгүй хувь нь сургалтад хамрагдсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| **2** | Эсэн мэнд амаржихуйн чиглэлээрх МСС-ны төрөл, хүртээмж, санхүүжилт нэмэгдэх ЛОББИ хийж, түншлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Лобби уулзалтын арга хэмжээг жил бүр хийж, түншлэгчдийн 30-аас доошгүй хувь нь хувийн болон ТББ байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ, НҮБ-ын ХАС-тай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн тайлан |
| **3** | Жирэмсэлтэд бэлтгэх багцыг туршин, нэвтрүүлэх | 21 аймаг, 9 дүүрэгт нэвтэрсэн байна. | Аймаг нийслэлийн ЭМГ-ын мэдээ тайлан |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Зорилтот бүлгийнхний хангагдаагүй хэрэгцээг судалж, тэдэнд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргын талаарх сургалт сурталчилгааг тогтмолжуулж, хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, | 15-49 насны эмэгтэйчүүдийн дунд ГБТ-ийн хангагдаагүй хэрэгцээ 16% хүртэл буурсан байна | НҮТС /SISS/,ҮСА,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| 5 | Аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, давтан үр хөндөлтийг бууруулах сурталчилгааг зохиох | 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлт 33-аас доош буурсан байна. | НҮТС /SISS/,ҮСА,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| 6 | Үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч нарт сургалт зохион байгуулах, | Сургалтад үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй ЭМБ-ын мэргэжилтнүүдийн 70-аас доошгүй хувийг хамруулсан байна. | Стратегийн дунд хугацааны үнэлгээтэй эцсийн үнэлгээг харьцуулсан дүгнэлт |
| 7 | Өсвөр үеийнхэнд чиглэсэн НҮЭМ-ийн мэдээллийг тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлэн, орчин үеийн дэвшилтэт арга хэрэгслэлээр дамжуулан хүргэх | 15-19 насны охидын төрөлтийн түвшин 35-аас ихгүй болсон байх | НҮТС /SISS/,ҮСА,НҮБ/ ХАС/ХС, 2013 |
| 8 | Эх, нярайн эрүүл мэнд, өвчлөл эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, баримтын хуудас, мэдээлэл сурталчилгааны материал боловсруулан түгээх, | МСС-ны материалыг зорилтот бүлгийн 60 %- д нь хүргэсэн байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 9 | Нийгэмд суурилсан эх, нярайн нэн шаардлагатай тусламжийн талаарх сургалт сурталчилгааг зохион байгуулах, | Аймаг, дүүрэг бүрт 5-аас доошгүй удаа | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл, жендерийн тэгш байдал мэдрэмжийн талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, | Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 70% нь тусламж үйлчилгээ авах талаар мэддэг байх | Судалгаа, ХЭҮТ-ийн мэдээ тайлан |
| 11 | Эх, нярайд нэн шаардлагатай бичил элемент, эрдэс бодисоор баяжуулсан хүнс аминдэмээр хангах ажлыг өргөжүүлж, нийгмийн эмзэг хэсгийн эх нярайн хооллолт тэжээлийн дутагдлаас сэргийлэх ажилд нийгмийн нөөцийг бүрдүүлэх | Эмзэг бүлгийн эх, нярайг амин дэм, эрдэс бодисоор 100 хувь хангадаг эрх зүйн орчин бүрдсэн байна. | НЭМҮТ тайлан мэдээ |
| 12 | Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод тусламж үйлчилгээг үзүүлэх байгууллагын үйл ажиллагаар өргөжүүлж, чанаржуулах, | Нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байр аймаг, дүүргийн 30 хувьд байгуулагдсан байна. | ХЭҮТ-ийн тайлан мэдээ, Аймаг, Нийслэлийн Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 13 | Эх, нярайн эрүүл мэндийг сайжруулах, нөөц бүрдүүлэх чиглэлээр бусад улс орны тэргүүн туршлагуудыг нэвтрүүлэх, | 2011-2015 онуудад шинээр нэвтрүүлсэн туршлагын үр дүнгээр тооцно. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| **Стратегийн зорилт- 2. Эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хүрэх саад бэрхшээлийг (унааны зардал, бүртгэл, даатгалд хамрагдалт, санхүүгийн болон ѐс заншлын саад, алслалт) бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх,** | | | |
| 14 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдэд зайн оношлогоог нэвтрүүлэх | 21 аймагт бүрэн нэвтэрсэн байна | ЭХЭМҮТ,ЭМХТ-ийн тайлан мэдээ |

168

| | | | |
|---|---|---|---|
| 15 | НҮЭМ-ийн тусламжийг нүүдлийн амбулаториор үзүүлэх арга хэлбэр боловсронгуй болгож тогтворжих | Нүүдлийн амбулаторийн зориулалтын машинаар БОЭТ, аймгийн НЭ-үүдийн 50-иас доошгүй хувь нь хангагдаж жилд нэг удаа бүх сумдаараа үйлчилсэн байна. | БОЭТ, Аймгуудын ЭМГ-ын мэдээ, тайлан |
| 16 | Эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусламж, алсын дуудлаганд зарцуулах төсөв, эх, нярайг дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх болон буцаах зардлыг бодитойгоор тооцон, санхүүжүүлэх | Санхүүжилтээс шалтгаалж яаралтай тусламж, дээд шатлалын эмнэлэгт шилжүүлэх, буцаах үйл ажиллагаа саатсан тохиолдол гараагүй байх | Стратегийн дунд хугацааны үнэлгээтэй эцсийн үнэлгээг харьцуулсан үнэлгээ, ЭМЯ-ны статистик мэдээлэл |
| 17 | Алслагдсан сум, сум дундын эмнэлэг, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн хүний нөөцийг чадавхижуулж, тоног төхөөрөмжөөр хангаж, НҮЭМ-ийн загвар эмнэлгийн жишигт хүргэх | БОЭТ, АНЭ, сум дундын эмнэлгийн 50-аас доошгүй хувь нь загвар эмнэлгийн жишигт хүрсэн байна. | Загвар эмнэлгийн үнэлгээний тайлан, Аймгийн ЭМГ-ын тайлан мэдээ |
| 18 | Эх, нярайд үзүүлэх алсын дуудлага, түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг дээшлүүлэх, багаж тоног төхөөрөмж, эмийн байнгын бэлэн байдлыг хангах /тоноглогдсон автомашинтай болох/ | Алсын дуудлага, түргэн тусламжийн үйлчилгээний журам боловсрогдож, эмнэлгийн мэргэжилтнээс бусад ажилтныг сургалтад хамруулсан байна. Түргэн тусламжийн машинуудын 10-аас доошгүй хувь нь тоноглогдсон байна. | Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын тайлан<br>Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 19 | НҮЭМ-ийн эм, эмнэлгийн хэрэгслэлээр тогтвортой хангах нөхцөл бүрдэх | НҮЭМ-ийн эм хэрэгсэлд Засгийн газраас төсөвлөсөн хөрөнгө 2009 онтой харьцуулахад 50 хувиар өссөн байна. | Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн тайлан |
| 20 | Батлагдсан стандарт, удирдамжийн дагуу НҮЭМ/ Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол сургах | Тусламж, үйлчилгээ үзүүлэгчид жилд 1 удаа сургалтад хамрагдсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх | Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий ЭМБ-ын эмч, мэргэжилтнүүд цогц тусламж, үйлчилгээний журам, гарын авлагаар хангагдсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 22 | Өрх, сум, баг, алслагдсан бүс нутгийн эх, нярайн тусламж үзүүлэгч нарыг оновчтой байршуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг идэвхижүүлэх | Эрүүл мэндийн хуульд заасан тэтгэмжийг олгож хэвшсэн байна. | ЭМЯ-ны ТЗУГ-ын тайлан мэдээ |
| 23 | Өрх, сум, багийн эмч, эх баригчдыг эх, нярайн яаралтай болон нэн шаардлагатай тусламжийн чиглэлээр богино хугацааны сургалтанд бүрэн хамруулж, дадлагажуулах | Өрх сумын 1739 эмч, багийн эмч 1033, эх баригчид 814. бүгд-3586 хүн жилд 1-ээс дээш удаа сургалтад хамрагдсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 24 | Эх, нярайн амь насанд аюул тулгарсан зайлшгүй тохиолдолд хэрэглэх нөөц санг олон нийт хамт олонд түшиглэсэн туршлагыг дэлгэрүүлэх | 5-аас доошгүй аймагт туршлагыг дэлгэрүүлэх арга хэмжээг туршилтаар хэрэгжүүлсэн байна. | Орон нутгийн ЗДТГ-ын тайлан мэдээ, Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 25 | Дээд шатлалын эмнэлэгт зайлшгүй шилжүүлэх эх, нярайд шаардагдах зардлыг тооцож, орон нутаг, байгууллагын төсөвт тусгаж, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах | Аймгууд эрүүл мэндийн төсөвтөө тусгаж шаардлагатай тохиолдлуудыг бүрэн санхүүжүүлсэн байна. | ЭМГ-ын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ,Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 26 | Амь тэнссэн үеийн тусламжид онгоц, унаа дайчлах эрх зүйн орчинг бүрдүүлэх, гэрээ байгуулах, | Эрүүл мэндийн хуульд энэ чиглэлээр өөрчлөлт оруулсан байна | ЭМ-ийн хуулийн шинэчилсэн найруулга |

| | | | |
|---|---|---|---|
| **27** | Алслагдсан сум, сум дундын эмнэлгийг цэвэр усны эх үүсвэр, шаардлага хангасан ариун цэврийн газартай болгож, тохижуулах арга хэмжээг шат дараалалтай авч хэрэгжүүлэх | Стратегийн хэрэгжилтийн хугацаанд шинээр баригдсан сум, СДЭ-үүдийн цэвэр усны эх үүсвэр, шаардлага хангасан ариун цэврийн газартай байна. | ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын тайлан, Аймгийн ЭМГ-ын тайлан мэдээ |
| **28** | Шинээр байгуулагдаж буй хот суурин газарт ажиллаж буй эмч мэргэжилтнүүдийг эх, нярай эмэгтэйчүүдийн чиглэлээр тусламж үзүүлэх чиглэлээр сургалтанд хамруулах | Шинээр байгуулагдсан газарт ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийн 80-аас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна. | Стратегийн дунд хугацааны үнэлгээтэй эцсийн үнэлгээг харьцуулсан үнэлгээ |
| **29** | Эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх ажлыг турших | Эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Хувийн хэвшлийн ЭМБ болон ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг нэмэгдүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих ЭМБ-ын сонгон шалгаруулалтын мэдээ, мэдээлэл, ХХЭМБ-ын тайлан |
| **Зорилт- 3. Эх, нярай, эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, нотолгоонд тулгуурласан анагаах ухааны дэвшилтэт шинэ арга технологийг нэвтрүүлэх** | | | |
| **30** | Амаржих газруудын "Амаржих газруудын бүтэц, үйл ажиллагааны стандарт"-ийн дагуу хүний нөөц шат дараалалтай бэлтгэх | 200-аас доошгүй эмч, эх баригчид бэлтгэгдсэн байна | Амаржих газрын стандарт MNS6188:210 Магадлан итгэмжлэлийн үнэлгээний тайлан, ЭМЯ-ны статистик мэдээ |
| **31** | Амаржих газруудын "Амаржих газруудын бүтэц, үйл ажиллагааны стандарт"-ийн дагуу багаж тоног төхөөрөмжийг хэрэгцээг тогтоож, хангах | Эх барих, нярайн тусламжийн нэн шаардалагатай багаж,төхөөрөмж, 5 төрлийн цомгоор бүрэн хангагдсан байна. | Амаржих газрын стандарт MNS6188:210, Магадлан итгэмжлэлийн үнэлгээний тайлан |

171

| | | | |
|---|---|---|---|
| 32 | ЭНЭШТөвийн эмч мэргэжилтнүүдийг орон нутагт зөвлөгөө өгөх, сургалт явуулах, судалгааны ажил хийх чадавхийг сайжруулах чиглэлээр сургаж бэлтгэх | Зөвлөх, тэргүүлэх зэргийн эмч нар 100 хувь сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн байна. | ЭХЭМҮТ-ийн бүртгэл, мэдээлэл |
| 33 | Шинээр ашиглалтанд орох Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, амаржих газарт ажиллах эмч мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж, сургалтанд хамруулж, бэлтгэх | Сонгон шалгаруулалтын журам батлагдан мөрдөгдөж сургалтад бүрэн хамрагдсан байна. | Сайдын тушаал, ТЗУГ, Аймаг, НЭМГ-ын тайлан, бүртгэл мэдээлэл |
| 34 | Эх, нярайд тусламж үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг хянаж, шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх | Ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдэн мөрдөгдсөн байна. | Сайдын тушаал, ТЗУГ, Аймаг Нийслэлийн ЭМГ-ын тайлан мэдээлэл |
| 35 | Эх, нярайд эмнэлгийн тусламжинд шаардагдах нэг удаагийн хэрэгслэлээр бүрэн хангах | Төрөлт бүрт 1 удаагийн цомог хэрэглэдэг болсон байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 36 | Пренатал оношлогоо, эмчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, лабораторийн чадавхийг сайжруулах | Удам зүй, үргүйдлийн оношилгоо, эмчилгээ, нярайн эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлсэн байна. | ЭХЭМҮТ-ийн тайлан мэдээ |
| 37 | Нярайн эрүүл мэндийн тандалт шинжилгээг нэвтрүүлэх | Тандалтын алба, нэгж байгуулагдаж, үйл ажиллагааны журам батлагдаж хэрэгжсэн байна. | ЭХЭМҮТ, Аймаг,Нийслэлийн ЭМГ-ын тайлан, эрүүл мэндийн сайдын тушаал |
| 38 | 2008-2010 онд эндсэн эхийн эндэгдлийг “Итгэмжит лавлагаа”-ны аргаар судалж, сургамж, зөвлөмж гаргаж холбогдох ажлыг зохиох | Эхийн эндэгдлийн түвшин буурч, Мянганы хөгжлийн зорилтод хүрсэн түвшинг ахиулсан байна. | Судалгааны тайлан, Эрүүл мэндийн сайдын тушаал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан |

| | | | |
|---|---|---|---|
| 39 | Хөх болон умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэлтийн тандалтыг нэвтрүүлэх | Эдгээр хавдраар өвчлөгсдийн 68.0 /62.0/%-ийг эхний шатанд оношилсон байна. | ЭМЯ-ны статистик мэдээ, ХСҮТ, Аймаг, Нийслэлийн мэдээ тайлан |
| 40 | Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийг илрүүлж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах, | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 30-аас доошгүй хувийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна. Өсвөр үеийнхэнд зориулж шинээр байгуулагдсан клиникийн тоо өссөн байна. | ЭМЯ-ны статистик мэдээний үзүүлэлтийн сүүлийн 5 жилийн дундачтай харьцуулна. |
| 41 | Эх, нярайн тусламжийн өртөг, зардлыг олон улсын аргачлалын дагуу тооцож, санхүүжилтийг боловсронгуй болгох | Эх, нярайн тусламжийн өртөг, зардлыг бодитойгоор тооцох аргачлал боловсрогдсон байна. | Стратегийн дунд хугацааны үнэлгээтэй эцсийн үнэлгээг харьцуулсан үнэлгээ |
| 42 | НҮЭМ-ийн багц тусламж үйлчилгээ, ялангуяа эх барих, нярайн яаралтай болон нэн шаардлагатай тусламжийн талаарх анагаахын сургуулиудын төгсөлтийн өмнөх, дараах сургалтын хөтөлбөрийг эргэж хянаж, боловсронгуй болгох | Хөтөлбөр шинэчлэгдэж сургалтад мөрдөгдөж эхэлсэн байна. | Анагаахын сургуулиудын хөтөлбөрийн үнэлгээ |
| 43 | Эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж буй стандарт удирдамж, журмуудыг нотолгоонд тулгуурлан шинэчлэн боловсруулах | 10-аас доошгүй стандарт, удирдамж, журам шинэчлэгдсэн байна. | ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан удирдамж журмууд |
| 44 | Батлагдсан стандарт, удирдамжийн дагуу НҮЭМ/ Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг тогтмол сургах, дадлагажуулах | 2015 онд ажиллаж байгаа сум,өрхийн эмч нарын 80 хувь, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригчид 100% сургалтад хамрагдсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 45 | Эх, нярайн амь насанд заналхийлсэн ноцтой хүндрэлийн тохиолдлыг бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, жил тутамд үнэлж, зөвлөмжийг хэрэгжүүлэх | Мэдээллийн сан бүрдэж зөвлөмжийн 60-аас дээш хувь хэрэгжсэн байна | ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны албаны мэдээлэл |

173

| | | | |
|---|---|---|---|
| 46 | Үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн үйлчилгээг эрүүл мэндийн тусламжийн шатлал бүрт хэрэгжүүлж, “Эх, нярайд ээлтэй эмнэлэг” шалгаруулах, | Эх, нярайд ээлтэй эмнэлгийн тоо жил бүр 5-аас доошгүйгээр нэмэгдсэн байна. | ЭМЯ,Аймаг, Нийслэлийн ажлын хэсгийн мэдээ, ЭМ-ийн сайдын тушаал |
| 47 | “Гамшиг осол, онцгой үеийн НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний байнгын бэлэн байдлын төлөвлөгөө”-г орон нутгийн засаг захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрт боловсруулан, нөөцийг бүрдүүлэх | Үндэсний хэмжээнд онцгой байдлын үеийн үйлчилгээнд хүүхэд, эмэгтэйчүүдийн хамрагдалтыг 50%-д хүрсэн байна. | НҮБ-ын ХАС-тай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хяналт шинжилгээний тайлан |
| 48 | Халдварт өвчинтэй жирэмсэн эхэд үзүүлэх өвөрмөц тусламжийг чанаржуулж, хүний нөөцийг чадавхижуулах | ХӨСҮТ,АНЭ-үүдийн халдвартын эмч нарыг өвөрмөц тусламж үйлчилгээний сургалтад 2 жилд 1 удаа хамруулсан байна. | Эх нярайн эрүүл мэнд стратегийн тайлан, мэдээ |
| 49 | Эх, нярайд тусламж үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй халдвар хамгааллын журмын мөрдөлтийг тогтмол хянаж, эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээг шуурхай авч хэвших | Жирэмсэн, төрөх,төрсний дараах хүндрэлд халдварын эзлэх хувь 0.05 аас доош буурсан байна. | ЭМЯ-ны статистик |
| 50 | Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд эх барихуйн чиглэлээр сургалтад хамруулах, мөрдөгдөж буй стандарт, удирдамж, журам зааврыг танилцуулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн 50-аас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна. | Хяналт, үнэлгээний тайлан |
| 51 | Эх, нярайд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанарыг үнэлэх аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх, чанарын менежер- үнэлээчдийг бэлтгэх | Магадлан итгэмжлэлийн Шалгуур 22.1-22.7-г үнэлэх аргачлалын дагуу үнэлээчид бэлтгэгдсэн байна. | ЭМБ-ын чанарын алба,нэгжийн мэдээ, тайлан |

| | | | |
|---|---|---|---|
| 52 | Шинэ хөлдөөсөн сийвэнгийн аймаг, орон нутгийн нэгдсэн эмнэлэгт нөөцийг бүрдүүлэх | Цусны салбар банкууд хөлдөөсөн сийвэн бэлтгэх тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна. | ЦССҮТ-ийн нэгдсэн тайлан, мэдээ |
| 53 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн цусны АВО болон резус бүлгийг тодорхойлох, жирэмсэн эмэгтэйчүүдэд давтан тодорхойлох ажлыг бүрэн хийж хэвшүүлэх, | Резус бүлэг тодорхойлох шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийг 100 хамруулсан байна. | ЭМЯ-ны статистик мэдээ, ЦССҮТ-ийн нэгдсэн тайлан, мэдээ |
| 54 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний цусны аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтанд хамруулах | Цус сэлбэх үйл ажиллагаанд оролцдог эмч, эмнэлгийн мэргэжилтний 50-аас доошгүй хувийг сургалтад хамруулсан хамруулсан байна. | ЦССҮТ-ийн нэгдсэн тайлан, мэдээ |
| 55 | Сумын эмнэлэгт болон яаралтай тохиолдолд цусны үл нийцэлтэй тохиолдолд хэрэглэх цус орлох бэлдмэлүүдийн нөөцийг бий болгох | Сум бүрт цусны бүлэг бүрээр 3-4 донорыг бэлтгэсэн байна. | ЦССҮТ-ийн нэгдсэн тайлан, мэдээ |
| 56 | Нярайн нас баралт, ялангуяа перинатал эндэгдлийн бүртгэл мэдээллийн бодит байдлыг олон улсын жишигт нийцүүлэн чанаржуулах | Нярайн нас баралт, перинатал эндэгдлийн бүртгэл мэдээллийн цахим программыг нэвтрүүлсэн байна. | ЭМХТ-ийн тайлан, хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт |
| 57 | Үргүйдэлтэй хосод үзүүлэх тусламжийг чанаржуулах, орчин үеийн оношлогоо эмчилгээний аргыг нэвтрүүлэх | Эрүүл мэндийн сайдын 259 тоот тушаалын заалт бүрэн хэрэгжсэн байна. | ЭХЭМҮТ-ийн тйалан |
| 58 | Үргүйдэл, перинаталоги, эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмгэг, андрологийн чиглэлээр эмч мэргэжилтнийг гадаадын улс оронд сургах | Сургагдсан хүний тоо стратеги хэрэгжих хугацаанд жил бүр нэмэгдсэн байна. | ЭХЭМТ-ийн хүний нөөцийн тйалан, ЭМЯ,ТЗУГ-ын нэгдсэн мэдээлэл |
| 59 | Эх, нярайн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн судалгааны ажлын хэрэгцээг тогтоож, төсөл шалгаруулж хэрэгжүүлэх ажлыг дэмжих | Нийт төслийн 40-өөс доошгүй хувь нь эх нярайн эм-д чиглэсэн байна. | Хэрэгцээний судалгааны тайлан, ШУТС-ийн нэгдсэн мэдээлэл |

| | | | |
|---|---|---|---|
| 60 | Эх, нярайн эрүүл мэндийн чиглэлээр судлаачдыг чадавхижуулж, сургалтанд хамруулах | ЭХЭМҮТ, НЭМҮТ-ийн ийн ЭША-нуудыг сургалтад бүрэн хамруулсан байна. | ЭХЭМҮТ-ийн ЭША-ын тайлан, |
| 61 | Сургалт, судалгаа, үнэлгээний ажилд мэргэжлийн нийгэмлэгүүд, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн оролцоог нэмэгдүүлж, институтчилэх | ЭХЭМҮТ болон НЭМҮТ, ЭМХТ-болон МЭЭЭНН, Хүүхдийн эмч нарын нийгэмлэгүүдийн оролцоо сайжирсан байна. | ШУТС-ийн нэгдсэн мэдээллийн сан, Мэргэжлийн нийгэмлэгүүдийн тайлан мэдээ |
| 62 | Судалгаа шинжилгээний ажлын үр дүнг эргэж мэдээлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Практикт шилжүүлсэн судалгааны үр дүнгийн тоо стратеги хэрэгжүүлэх хугацаанд өссөн байна. | Үнэлгээний тайлан |
| 63 | Эх, нярайн өвчлөл, эндэгдлийн бүртгэл мэдээллийг чанаржуулах | Эх, нярайн өвчлөл эндэгдлийн тандалтын журамд 2011 оноос орсон өөрчлөлт, шинэчилж чанаржуулсан бүртгэл мэдээллийн тоо | ЭМХТ-ийн тайлан |
| **Бусад үйл ажиллагаа** | | | |
| 64 | Эх нярайн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан бий болгох, | ДЭМБ, ХАС-ийн замын зураг хэрэгжсэн байх | НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын мэдээлэл, ЭМЯ-ны хамтын ажиллагааны мэдээлэл |
| 65 | Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг тооцох ажлыг тогтмолжуулах | Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, стратеги бүрт үнэлгээ хийж үр дүнг тооцсон байна. | Үнэлгээний тайлангууд |

Тайлбар: ***2013 онд Эх нярайн эрүүл мэнд стратегийн хэрэгжилтэд дунд хугацааны үнэлгээ хийсэн тул төлөвлөгдсөн ажлуудын гүйцэтгэлийн эцсийн үнэлгээний шалгууруудыг шинэчлэн боловсруулав.***